

## ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

### Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын Иргэдийн тэргүүлэгчдийн ээлжит 10 дугаар хуралдаан 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, сумын 2023 оны төсвийг хэлэлцэн баталлаа. 2023 оны орон нутгийн төсвийн хүрээнд хөдөө аж ахуй болон малчид руу чиглэсэн 171 сая төгрөгийн 11 ажил, арга хэмжээг малын тоо толгойн татвараар хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал мал угаалгын тарифд хөнгөлөлт үзүүлэхэд 33 сая, худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэх ажил 48 сая төгрөг, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зориулж 19 сая төгрөг гэх мэт ажлууд тусгагдсан байна.

Аймгийн засаг даргын 2022 оны А/593 дугаар захирамж, сумын Засаг даргын А/145 дугаар захирамжаар 2022 оны жилийн эцсийн өрх, хүн ам, хөдөө аж ахуйн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Тооллогын ажлыг 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн ажлын 9 хэсэгт багийн засаг дарга нар, багийн иргэд нийтийн хурлын дарга, төрийн албан хаагчид, малын эмч, жолооч нарын 31 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсан.

Тооллогын ажлын хэсгүүд 12 дугаар сарын 7-ны өдрийн 07 цагаас эхлэн эхлэн малчин өрхийн хотонд очиж тооллогын ажлыг зохих заавар журмын дагуу хийж 12 дугаар сарын 17-ны өдрийн хооронд тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тооллогын ажилд Сүхбаатар аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Алтаннар ахлагчтай ажлын хэсэг 12 дугаар сарын 11-нд ирж Өгөөмөр багийн нутагт өвөлжиж байгаа өрхүүд болон тооллогын комиссын ажилтай нь газар дээр нь очиж танилцаж ажилласан.

Мөн тооллогын ажилд сумын хяналтыг сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар 12 дугаар сарын 12-ны өдрөөс 13-ны өдрийн хооронд хяналтын тооллогыг Өлзийт, Өгөөмөр багийн нийт 23 өрхөөр орж хийж тооллогын ажлын хэсэгтэй уулзаж заавар зөвлөгөө өгч хийсэн ажил байдалтай нь газар дээр нь танилцаж ажилласан.

### **Хүн ам:**

Нийт хүн ам 3454 болж, өмнөх оныхоос 20 хүнээр өсөж, 2022 онд 57 хүүхэд шинээр мэндэлж, шилжин ирсэн хүн ам 53, шилжин явсан 83, шилжин ирсэн өрх 8, шилжиж явсан өрх 13, нас барсан 20 хүн, шилжиж ирсэн хүнээс 47% хүн нь өөрийн аймгийн сумдаас, 53% нь бусад аймаг, сумдаас ирсэн байна.

Аймгийн ХХҮГ-ын даргын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн "БЯЦХАН ҮРС ӨВДӨХГҮЙ" аяны арга хэмжээг удирдамжийн дагуу сумын хэмжээнд 2022 оны 11-р сарын 29-ны өдрөөс 2022 оны 12-р сарын 05-ны өдрүүдэд сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, хувьд хүмүүстэй хамтран зохион байгууллаа.

"БЯЦХАН ҮРС ӨВДӨХГҮЙ" аяны арга хэмжээнд сумын 7 албан байгууллага, 5 аж ахуйн нэгж, 3 өрхийн хувь хүмүүс оролцож нийт 4,636,600 төгрөгийн бодит дэмжлэгийг зорилтот 13 өрхийн 0-5 насны хүүхэдтэй өрхөд хүлээлгэн өгөхөд бэлэн болж, сургуулийн захиргааны хүсэлтээр бүтэн өнчин 3 хүүхдийг нэмж нийт 16 өрхөд хүргэх ажлыг зохион байгууллаа.

### **Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

**Мал тооллогын талаар:** Хөдөөгийн 4 багийн хот айл байршлын судалгаа, графикийг гаргаж Өлзийт багт 2 ажлын хэсэг, Сэргэлэн багт -1, Үнэгт багт 1 ажлын хэсэг, Дэлгэрхаан багт 1 ажлын хэсэг, Өгөөмөр багт 2 ажлын хэсэг, Отрын нутагт – 1 ажлын хэсэг гарган 390 хот айлд, нийт 8 автомашин 4200 км явж тоолсон байна.

Мал тооллогын өдрүүдэд малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож малыг нэг бүрчлэн нүд үзэж тоолж, тоолсон тухай хотны малын цайралт хийж хотны малын бичиг үйлдэж МТ-1 маягтын дагуу бүртгэл мэдээллийг бүрэн хийж ажиллалаа.

Нийт малчин өрхийн малчдын тоо 1402 үүнээс 16-34 насны 521, 35-59 насны эрэгтэй малчин 762, 60-аас дээш насны малчин 119. Нийт малчдаас эрэгтэй 807, эмэгтэй 595 тус тус ажиллаж байна.

851 малтай өрхөд, 7 тавиул малтай өрх, 5 аж ахуйн нэгжид 416461 толгой мал тоологдсоны дотор : Тэмээ-1362, Адуу-22704, Үхэр-21798, Хонь-215342, Ямаа-155255 толгой мал тус тус тоологдсон байна.

Нийт малд эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ-0,3%, адуу-5,5%, үхэр-5.1%, хонь-51.9 %, ямаа-37,2% тус тус эзэлж байна.

Нийт мал өмнөх оноос

- тэмээ -134
- Адуу – 2930
- Үхэр - 3485
- Хонь – 27010
- Ямаа - 20530 толгойгоор, нийт 54089 толгойгоор тус тус өссөн байна.

164404 толгой эх мал төллөснөөс Ингэ-497, гүү-6595, үнээ-7447, эм хонь-90010, эм ямаа-59855 эм мал төллөсөн байна.

Төллөсөн эхээс нийт 130346 толгой төл гарч ботго 273, унага 5374, тугал 7060, хурга 74149, ишиг 43490 гарсан байгаа бөгөөд тугал 6, хурга 28, ишиг 59 хорогдсон байна.

Төл бойжилтын хувь 99,9 буюу унага 100%, тугал-99,9%, ботго 100%, хурга 99,9%, ишиг 99,8% бойжсон байна.

Ханын хэцийн хүрэн тэмээ 98 тоологдож өнгөрсөн жилийнхээс 18-аар өссөн байна.

Мөн цэвэр эрлийз малын тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулж үзэхэд цэвэр үзэмчин хонь – 18137 энэ нь өмнөх оноос өссөн байна.

Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямаа өмнөх оноос 14225 толгойгоор өссөн, Баяндэлгэрийн улаанаар сайжирсан сүрэг 1066 толгойгоор буурсан байна.

Нутгийн шилдэг омог, цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн сайжруулсан үүлдрийн малын тоо 223376 болж өмнөх оноос 32157 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.

292 өрх, 792 тн өвс худалдан авч, 32 өрх 57.5 тн таримал тэжээл, 14 өрх 5.9 тн гар тэжээл, 82 өрх 368тн хужир шүү, 3 өрх 12тн сүрэл, 761 өрх 1350 тн аргал, 827 өрх 2523 тн хөрзөн бэлтгэснийг шивж оруулсны дагуу мэдээллийн санд нэгтгэсэн.

Хөдөө аж ахуйн салбарт ашиглагдаж буй авто машин техник энэ тооллогоор худгийн насос 91 өрхөд 91 насос, 305 өрхөд ачааны машин 311, 393 өрхөд суудлын машин-401, 471 өрхөд 482 мотоцикль бүртгэгдэж өмнөх оны тоон үзүүлэлтээс өссөн дүнтэй байгаа нь малчин өрхийн худалдан авах чадвар нэмэгдсэнтэй холбоотой.

Худаг уст цэгийн тооллогын дүнгээр 168 өрхөд 171 худгаас гүн өрмийн 40, энгийн уурхайн 131, худаг нь өөрийн эзэмшлийн 9, дундын эзэмшлийн 162 худаг тоологдсон байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:**

Боловсролын чиглэлээр: ЕБС: 2022-2023 оны хичээлийн жилийн нэгдүгээр улирлын хичээл 16 долоо хоног хичээллэж, дууслаа. 1-р ангийн сурагчид энэ хугацаанд сурсан мэдсэн зүйлээ эцэг эх, асран хамгаалагч хамт олондоо тайлагнаж амжилтын баяраа хийлээ.

Суралцагчдыг массаар сурган, сэтгэн бодох, бодлого бодох үйл ажиллагаа хөгжүүлэх зорилгоор 2-5-р ангийн дунд Математикийн өртөөчилсэн буухиа тэмцээнийг амжилттай зохион явууллаа.

“Бяцхан үрс өвдөхгүй” аяны хүрээнд сургуулийн сурагчдад эрүүл мэндийн талаар анхан шатны мэдлэг олгож анги хамт олноороо “Дархлаажуулалт”-нд хамруулах саналыг сургуулиас гаргаж анги бүлгийн эцэг эхийн дэмжлэгтэйгээр сургуулийн 1-12 дугаар ангийн 25 анги бүлгийн хүүхэд хамрагдаж эцэг эхээс 711 хүүхдэд 7 сая 812 мянга 620,000 төгрөгний витаминжуулалтыг хийсэн. Сургуулийн захиргааны зүгээс сургуулийн багш ажилчдын 0-5 насны 35 хүүхэд тус бүрт 5300 төгрөгний витаминжуулалт хийж 185500 төгрөг зарцууллаа.

Цэцэрлэг: Дээд газраас ирж буй захирамж, тушаал шийдвэр, зөвлөмжийг мөрдөн, хугацаат болон хариутай бичиг, тоон мэдээг тогтмол цаг хугацаанд нь хүргэн, үүрэг чиглэлийн дагуу ажиллаж байна. Халаалт дулаан хэвийн үргэлжилж 7хоногт 2 удаа их цэвэрлэгээ ариутгалыг тогтмол хийж, халдвар хамгааллын дэглэм баримтлан эрсдэлгүй орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Эрхлэгч, аргазүйч, 8 багшийн хамт Улаанбаатар хотын “Шиномед” эмнэлэгтэй гэрээ хийж багш нарын нэмэлт шинжилгээнд бүрэн хамрагдлаа.

8 бүлгийн багшийн дунд “Боловсрол дахь ёс зүй” сэдвээр илтгэлийн уралдаан зарлаж шилдэг илтгэлүүдийг шалгаруулж 2-р шатанд явууллаа.

БШУГ-аас авдаг 4 чиглэлийн тайлан мэдээг цаг хугацаанд нь бичиж хүргүүлээ.

Дотоод хяналтын баг багш ажилчид руу чиглэсэн удирдамжтай хяналт шалгалтыг 1 удаа хийж гарсан алдаа хийж дутагдлыг дор бүр арилгаж зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.

Хүүхдийн цэцэрлэг байгууллагын хамт олон “Бяцхан үрс өвдөхгүй” аян хүрээнд “Дүүрэн сагс” сайн дурын үйл ажиллагааг байгууллага дээр аялуулж нийт 30 багш, ажилчин албан хаагч нар 100% хамрагдаж нийт 1046,000 төгрөгийн хүнс болон бараа бүтээгдэхүүнийг хуримтлуулан дэмжлэгийг хүлээлгэн өглөө. Байгууллагынхаа албан хаагчдын хүүхдүүдийн дархлааг дэмжин нийт 31 хүүхдэд хүүхэд бүрт 20,000-ийн багц чацаргана, Витамин-С, амны хаалт, витамин Д нийт 620,000 төгрөгийн зарцуулсан.

0-5 насны хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд нийт 2-5 насны 166 хүүхдийг цэцэрлэг дээр нэгдсэн журмаар үзлэгт хамруулж, хүүхдүүдийг өдөрт 2 удаа халуун аарц, чацаргана, аньсны шүүс уулгаж дархлааг дэмжиж байна.

Соёл: Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Соёл урлагийн салбарын 2022 оны тайлангийн хурал, сургалт, зөвлөгөөнд байгууллага хамт олноороо оролцож 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлаа В үнэлгээтэй дүгнүүлж 4-р байранд орсон.

Нийт албан хаагч нар байгууллагын шинэ жилийн үйл ажиллагаанд зориулан засал, чимэглэл хийж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Номын сан нь 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж фонд баяжилтын номд техник ажиллагааг хийж уншигчдад хүргэн ажиллаж байна. Номын сангаар 12 сард нийт 22 уншигч үйлчлүүлж, 41 номыг олгосон.

“Судар- Эгшиглэн” төсөлд оролцогчдын 29 материалыг Сүхбаатар аймгийн нийтийн номын санд хүргэн ажиллалаа.

Соёлын төв нь 2022 онд 8-н төрлийн дугуйланд нийт 134 сурагчид хамрагдан суралцаж байна.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 542, алсын дуудлага 12, гэрийн дуудлага 5, хэвтэн эмчлүүлэгч 0. Мөн сар болгон хийгддэг товлолын вакциныг 46 хүүхдэд хийгээд байна. Ковидын вакцинжуулалтад – 0.

Халдварт халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 95%-тай байна.

0-17 насны эрт илрүүлэг үзлэгийн бүртгэлийг ihospital цахим программд шивж оруулав. Нийт үзлэг: 76 %

Томуу томуу төст өвчний вакцинд 430 хүн хамрагдсан байна.

Тухайн сард лабораторийн хийсэн шинжилгээ үйлчилгээ: Сахар – 4, В, С вирус илрүүлгийн шинжилгээ-8, серологи – 7, шээсний ерөнхий шинжилгээ – 23, ковид -24.

ЭМТ-нь байгууллагынхаа ажилчдын хүүхдүүдэд витаминжуулах арга хэмжээнд 5 төрлийн 24 өрхийн хүүхдийг хамруулж, нийт 179000 төгрөгийн дархлааг дэмжих витаминжуулалт багцад хамруулсан.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг